



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Цагаан толгой трейд” ХХК-д үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Цагаан толгой трейд” ХХК /Т.Уянга/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН